



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/702

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 03/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхагласны 97 жилийн ой, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга нарын сургалт, зөвлөгөөний арга хэмжээнд зориулсан хүчит бөхийн барилдааны зардалд 1 000 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 1 000 000 төгрөг /нэг сая/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 4.4 дэх "Спортын аварга" хөтөлбөр, төслөөс 300 000 төгрөг, 4.14 дэх "Стандарттай Ховд" хөтөлбөр, төслөөс 700 000 төгрөгийг тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Дэлгэрсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Ховд аймгийн Засаг даргын 2021 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн
А/702 дугаар захирамжийн хавсралт



АНХДУГААР ҮНДСЭН ХУУЛИА БАТАЛЖ, БҮГД НАЙРАМДАХ УЛСАА
ТУНХАГЛАСНЫ 97 ЖИЛИЙН ОЙ, ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨНИЙ АРГА ХЭМЖЭЭНД
ЗОРИУЛСАН ХҮЧИТ БӨХИЙН БАРИЛДААНЫ ТӨСӨВ

№	Бай шагнал	Тоо хэмжээ	Нэг бөхийн бай шагнал	Нийт бай шагнал
1	1 давсан бөх	16	10 000	160 000
2	2 давсан бөх	8	20 000	160 000
3	3 давсан бөх	4	30 000	120 000
4	Шөвгөрсөн бөх	2	60 000	120 000
5	Үзүүр бөх	1	100 000	100 000
6	Түрүү бөх	1	150 000	150 000
Бай шагнал дүн				810 000
Дурсгалын зүйл				
1	Гарын даа	3	14 000	42 000
2	Засуул	4	14 000	56 000
3	Хөлийн цэц	2	14 000	28 000
4	Тайлбарлагч	1	14 000	14 000
5	Эмч	1	14 000	14 000
Дурсгалын зүйл дүн				154 000
Дурсгалын зүйл				
1	Медаль	4	6 000	24 000
2	Жааз, өргөмжлөл	4	3 000	12 000
Дурсгалын зүйл дүн				36 000
Нийт дүн				1 000 000

--oOo--